

Ёс зүйн хорооны 2024 оны ажлын төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт

2024.12.11

Мандалговь хот

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хугацаа /улирал/	Хэрэгжилт
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	Эмнэлгийн ёс зүйн хорооны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	50%	97%	I улирал	2024 оны 1 сард Ёс зүйн төлөвлөгөөг гаргаж Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн даргаар батлуулав. Хэрэгжилт 100%
2	Эмнэлгийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх	Сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо	15	15	15	Хагас жилд 1 удаа	Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм /11/, эмч эмнэлгийн ажилчдын хоорондын хэм хэмжээ /11/ зэрэг сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Ёс зүй, харилцаа, хандлага /17/, Эрүүл мэндийн байгууллагын соёлд хувь хүний хөгжил, үйлчилгээний стандартыг хэвшүүлэх нь сэдэвт сургалтанд /9/ нийт 48 ажилтныг хамруулав. Хэрэгжилт 100%

3	Шинээр ажилд орж байгаа ажилтанд ёс зүйн сургалтыг зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	5	гүйцэтгэл		Тухай бүрт	Үйлчлэгч Мягмарсүрэн, их эмч Цэрэнханд нарт эмнэлгийн ёс зүйн хэм хэмжээ болон зарчмын талаар сургалтын материал бэлдэн оров. Хэрэгжилт: 100%
4	Эмч эмнэлгийн ажилчдыг ёс зүйн багц цагийн сургалтанд хамруулах	Ёс зүйн багц цагийн сургалтанд хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	11	5	6	Тухай бүрт	Эрүүл мэндийн байгууллагын соёлд хувь хүний хөгжил, үйлчилгээний стандартыг хэвшүүлэх нь сэдэвт 2 цагийн багц сургалтанд нийт 5 ажилтныг хамруулсан. Хэрэгжилт 100%
5	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс олон нийтийн сүлжээгээр авах	Сэтгэл ханамжийн судалгаа авсан иргэдийн тоо	-	60	90	Улирал бүр	Хагас жилийн үнэлгээгээр нийт 100 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан. Хэрэгжилт 100%
6	Байгууллагын соёл, ажилтны хандлага, эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	15	18	20	Улирал бүр	Байгууллагын соёл, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, Ёс зүй, харилцаа, хандлага сургалтыг сургалтын

	хэм хэмжээ сургалт зохион байгуулах						төлөвлөгөөний дагуу 3 удаагийн давтамжтай зохион байгуулсан. Хэрэгжилт 100%
7	Өглөөний уулзалт зохион байгуулах / эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдын баярыг угтан тулгамдаж буй асуудал, чин сэтгэлийн ярилцлага хийх/	Хамрагдалтын хувь	3	2	1	Тухай бүр	Кофетой уулзалт-2024 эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн нартай өглөөний уулзалт зохион байгуулав. Нийт 6 ажилтан хамрагдаж 8 саналыг гарган ярилцлага өрнүүлэв. Зангиагүй ярилцлага-2024 сувилагч, тусгай мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулав. Нийт 5 ажилтан хамрагдаж 7 саналыг гарган ярилцлага өрнүүлэв. Хэрэгжилт 100%
8	Уламжлалт болгон зохион байгуулах арга хэмжээ	Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан ажилчдын тоо	6	2	4	I-IV улирал	Уламжлалт болгон зохион байгуулах 6 арга хэмжээнээс Чанар, аюулгүй байдлын албанаас Их эмч, сувилагч нарын баярыг зохион байгуулав. Уг арга хэмжээгээр 4 багт хувааж "Яг түүн шиг" энтертаймент тэмцээнийг зохион байгуулав. Тэмцээний ялагчаар Х.Чирчинсүрэн, С.Сүхбат

							ахлагчтай 2 баг шалгарч мөнгөн урамшууллаар шагнагдав. 11-р сарын 15-нд Эмнэлгийн ажилчдын баярыг Дотоод хяналтын баг зохион байгуулж нийт ажилчид хамт олноороо оролцож тэмдэглэв.
9	Ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах	Хамрагдсан ажилчдын тоо	-	-	20	IV улирал	Амбулатори болон хэвтэн эмчлүүлэгчдээс сар болгон сэтгэл ханамжийн судалгааг, цахим болон цаасан хэлбэрээр авч ажилласан. Хэрэгжилт 100%

Тайлангийн хэрэгжилт бичсэн: Их эмч

Б.Болормаа

Б.Болормаа